

БАТЛАВ:

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА

Ч.ХУРЭЛБААТАР
Ч.ХУРЭЛБААТАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД
Ц.НЯМДОРЖ
Ц.НЯМДОРЖ

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1. Хууль зүйн үндэслэл

1.1. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд "Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана" гэж тунхагласан.

1.2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д Монгол Улсын иргэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ гэж заасан.

1.3. Монгол Улсын Засгийн газраас 2010 оныг "Бизнесийн орчны шинэтгэлийн жил" болгон зарласан бөгөөд уг жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.12-т "Мэдээллийн ил тод /эрх чөлөө/ байдлын тухай хуулийг төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлнэ" гэж заасан.

2. Практик шаардлага

Хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх Монголын ард түмний эрхэм зорилгод нийцүүлэн төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй, шударга, шуурхай, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдал болон иргэдийн мэдээлэл авах эрх, эрх чөлөөг хангах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төслийг батлан гаргах замаар энэхүү шаардлагыг хангах нь зүйтэй байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 6 бүлэгтэй байх бөгөөд төсөлд дараахь асуудлыг тусгана:

1-р бүлэгт хуулийн зорилт, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт болон мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах үйл ажиллагаанд баримтлах зарчмын тухай;

2-р бүлэгт мэдээллийн ил тод, нээлттэй байдлын төрөл, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор төрийн байгууллага /Олон нийтийн радио, телевиз/-аас авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай;

3-р бүлэгт иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрх чөлөө, төрийн байгууллага /Олон нийтийн радио, телевиз/-аас иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх журмын тухай;

4-р бүлэгт зарим төрлийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөхийг хориглох тухай;

5-р бүлэгт мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих тухай;

6-р бүлэгт мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн дараахь зэрэг үр дагавар үүснэ гэж үзэж байна:

1.иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгод хүрэх үйл явцыг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдолтой төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй, шударга, шуурхай, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангах нөхцөл бүрдэх;

2.төрийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоо нэмэгдэх, улмаар төр, иргэний харилцан итгэлцэл бэхжих;

3.төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд иргэний нийгмийн зүгээс хяналт тавих бодит нөхцөл нэмэгдэх;

4.авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаанд ахиц гарах;

5.төрийн албанд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, ашиг хонжсо олох, эдийн болон эдийн бус хэлбэрээр давуу ашигтай байдал болгох зэрэг хууль бус үйл ажиллагаатай тэмцэх ажилд тодорхой ахиц гарах;

6.иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл олж авах зардал тодорхой хувиар багасах.

Хуулийн төсөл батлагдсаны дараа уг хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай болох бөгөөд үүнд тодорхой хугацаа, хөрөнгө хүч шаардлагатай болно.

Тухайлбал, цахим хуудасгүй төрийн зарим байгууллагыг цахим хуудастай болгох шаардлагатай болно. Түүнчлэн хуульд заасан мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах чиглэлээр төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх шаардлагатай болох бөгөөд энэ чиглэлээр сургалт, семинарыг төрийн байгууллагын албан хаагчдын дунд бүсчлэн зохион байгуулна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуультай нийцэх бөгөөд хуулийн төсөптэй холбогдуулан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

-----oOo-----